



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization
Representative Office
for Mongolia

Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах олон улсын стандарт-IPSG :

1. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах
2. Үр дүнтэй харилцааг бий болгох
3. Өндөр эрсдэлтэй эмийн хэрэглээг сайжруулах
4. Буруу талбай , буруу ажилбар, буруу мэс ажилбар хийхээс сэргийлэх
5. Эмнэлгээс гаралтай халдварын эрсдэлийг багасгах
6. Явганаас унахаас сэргийлэх

PATIENT SAFETY GOALS



Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах гэж **зөв тусламж, үйлчилгээ** үзүүлэх зорилгоор тухайн үйлчлүүлэгчийн **хувь хүний өвөрмөц мэдээллийг** ашиглан дахин магадлах үйл явцыг хэлнэ.



Танин тодруулах туузан зүүлт гэж үйлчлүүлэгчийг зөв танин тодруулгад ашиглах хувь **хүний өвөрмөц мэдээлэл бүхий өнгөөр ялгасан нэг удаагийн хэрэглээний, эмнэлгийн зориулалтын туузыг** хэлнэ.



Хувь хүний өвөрмөц мэдээлэл гэж үйлчлүүлэгчийг зөв танин тодруулгад ашиглах тухайн үйлчлүүлэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он сар болон бусад мэдээллийг хэлнэ.

Хүүхдийн тасгийн 1 өрөөнд хэвтэн эмчлүүлж байсан.

.... Г.Э (2.1 настай, эм, жин - 12.5 кг) - Цефатаксим 500 мг * 8 цаг
(14, 22, 06 цаг)

.... Б.А (3.10 настай, эм, жин – 15.2 кг) - Цефатаксим 700 мг * 8 цаг
(09, 17, 01 цаг)

Хийгдсэн эмчилгээ:

.... Г.Э - 6 цагт – 500 мг, 9 цагт 700 мг

... Б.А – 01 цагт – 700 мг, 9 цагт (700 мг) хийгээгүй

Сувилагч Г. Э – т 14 цагт тариа хийхээр орох үед Б. А-ын ээж нь 9 цагийн тариаг хийгээгүй болохыг хэлсэн. 2 хүүхдэд эмийн цаг, тунг андуурч хийсэн болохыг мэдсэн.

Үр дагавар: • 1 хүүхдэд эмийн тунг хэтрүүлсэн • 1 хүүхдэд эмийн тунг багадуулсан • Үйлчлүүлэгчид ноцтой үр дагавар гараагүй

Үйлчлүүлэгчийн нэрийн давхардал



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Интермед ЭМС-дэх үйлчлүүлэгчийн бүртгэл - 69 423 (2017.04.17-ны байдлаар)

Нэр Тоо

Мишээл 389

Уянга 336

Хулан 321

Болормаа 311

Ананд 298

Энхтуяа 289

Билгүүн 288

Тэмүүлэн 265

Солонго 265

Дөлгөөн 256

Интермед ЭМС-дэх үйлчлүүлэгчийн бүртгэл-69423

Овог нэр

Ганбаатар Уянга

Батболд Хулан

Батбаяр Ананд

Анхбаяр Хүслэн

Батбаяр Хулан

Батжаргал Дөлгөөн

Ганбаатар Энхжин

Энхбаяр Билгүүн

Ганболд Гантуяа

Жаргалсайхан Солонго

Самбуу Алтанцэцэг

Ганболд Билгүүн

Давхардал

8

8

7

6

6

6

6

6

6

6

6

6 гэх мэт

Үйлчлүүлэгчийн нэрийн давхардал



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ХСҮТ-д 2016 оны 1 сарын 1-ээс 12 сарын 31 хүртэл хэвтэн
эмчлүүлсэн 9925

Нэр тоо

Овог нэр

Давхардал

Алтанцэцэг-192
Оюунчимэг-164
Цэцэгмаа-116
Нарантуяа-122

Дамдинжав Алтанцэцэг-3
Долгор Алтанцэцэг-3
Лхамсүрэн Алтанцэцэг-4
Мягмаржав Нарантуяа-3
Цэгмэд Оюунчимэг-3

Үйлчлүүлэгчийн мэдээллийг дутуу, буруу авах



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Үйлчлүүлэгчийн мэдээллийг Дутуу, Буруу авах нь эмнэлгийн алдааны үндсэн шалтгаан

Үр дагавар:

- Шинжилгээний хариу солигдох
- Оношилгоо оройтох
- Үйлчлүүлэгчид буруу эмчилгээ хийх
- Нас баралт



Танин тодруулах ерөнхий зарчим



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



- Үйлчлүүлэгчийн хувь хүний өвөрмөц мэдээллийг ашиглана.
- Үйлчлүүлэгчийн хэвтэн эмчлүүлж буй өрөөний болон давхарын дугаар, орны байрлал, хувцаслалтыг танин тодруулгад ашиглахгүй !!!.
- Бугуйн зүүлтэд ОУ-д баримталдаг өнгийг ашиглана.
- Үйлчлүүлэгчийг мөн эсэхийг тодруулахдаа асуухаас илүүтэйгээр өөрөөр нь хэлүүлэхийг чухалчилна.



Үйлчлүүлэгчийг танин тодруулах үйл ажиллагаа

Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахын тулд үйлчлүүлэгчийг таних бугуйн зүүлтийг хэрэглэнэ Үйлчлүүлэгчийг таних 2 аргыг хэрэглэдэг байх

ХАМГИЙН БАГАДАА 2 АРГААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТАНИНА.

Овог нэр
Төрсөн он сар өдөр

- Өрөөний дугаар
- Байрлал (тасаг нэгж)
- Орны байрлал
- Хувцаслалт




Үйлчлүүлэгчийг танин тодруулах үйл ажиллагаа



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



- Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахын тулд үйлчлүүлэгчийг таних туузан зүүлтийг хэрэглэнэ.
- Эмнэлгийн цахим системд үйлчлүүлэгчийн бүртгэх үед шаардлагатай мэдээллийг эрүүл мэндийн ажилтан лавлан бугуйн зүүлтийг зүүнэ.
- 0-18 насны хүүхэд бол эрүүл мэндийн ажилтан өөрөөс болон эцэг эх, асран хамгаалагчаас үйлчлүүлэгчийн мэдээллийг асууж эмнэлгийн мэдээллийн системд бүртгэнэ.



Ямар үйлчлүүлэгчид танин тодруулж бугуйвч зүүлгэх бэ?



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health Organization
Representative Office
for Mongolia

- Яаралтай тусламж, амбулаториор урьдчилан сэргийлэх үйлчилгээг 4 цагаас дээш хугацаагаар авах үйлчлүүлэгчид
- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авах үйлчлүүлэгчид
- Өдрийн эмчилгээнд хамрагдаж буй үйлчлүүлэгчид



Тасаг нэгж ямар үйл ажиллагаа хийх бэ ?



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ авах тасаг нэгжид хүлээн авсан эмнэлгийн ажилтан шаардлагатай мэдээлэл, эрүүл мэндийн байдал, эмнэлзүйн онцлог, хэрэглэгдэх эм, тариа, тухайн тасаг, нэгжид ижил нэртэй үйлчлүүлэгч байгаа эсэхийг тодруулан бугуйн зүүлтний өнгийг өөрчлөх эсвэл нэмж зүүлт хэрэглэнэ.



Бугуйн зүүлтний өнгө юуг илэрхийлэх бэ?



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Насанд хүрэгчдэд:

ЯГААН – эрчимт эмчилгээний үйлчлүүлэгч

ШАР өнгийн бугуйн зүүлтийг унах эрсдэлтэй үйлчлүүлэгчид

УЛААН өнгийн бугуйн зүүлтийг харшилтай (Эм тариа, хоол хүнс гм)

НОГООН өнгийн бугуйн зүүлтийг ижил нэртэй үйлчлүүлэгчид

ЦАГААН өнгийн бугуйн зүүлтийг эрсдэлгүй үйлчлүүлэгчдэд хэрэглэнэ.



Ерөнхий зарчим: мэс заслын үед танин тодруулах



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Мэс заслын талбайн тэмдэглэгээг эмчлэгч эмч хийнэ. Талбайн тэмдэглэгээг хийхдээ дараах байдлаар магадлана. Үүнд:

1. Аман хэлбэрээр тодруулга хийх
2. Мэс заслын хуваарьтай тулган үзэх
3. Мэс заслын зөвшөөрлийн хуудас, өвчний түүхийг шалгана

Мэс заслын талбайн тэмдэглэгээг

4. Үйлчлүүлэгчийн ухаан санааны байдал хэвийн байхад буюу унтуулга, мэдээ алдуулалт хийхээс өмнө хийнэ.
5. Хос эрхтэн, олон мөчид ба нуруу нугалмын мэс заслын үед заавал хийнэ.
6. Мэс заслын талбайн тэмдэглэгээ хийхдээ дараах зарчмийг баримтлана

Мэс заслын үед танин тодруулах



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Мэс заслын талбайн тэмдэглэгээ хийхдээ дараах зарчмийг баримтлана. Үүнд:

1. Мэс засал хийх эмч арьсны маркер ашиглан тэмдэглэгээг хийнэ.
2. Мэс засал хийх талбайд тухайн мэс заслын онцлогоос хамааран тохирох тэмдэглэгээг хийнэ.
3. Талбайн тэмдэглэгээг хийхдээ Х тэмдэг тавихыг хориглоно.
4. Мэс заслын талбайн тэмдэглэгээ нь талбайг ариутгаж, тусгаарласны дараа /тусгаарлах даавуу тавьсны дараа/ харагдахуйц байна.



Мэс заслын үед танин тодруулах



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



- Бугуйн зүүлтийг үйлчлүүлэгчийн биеийн мэс засал хийгдэхгүй талд зүүнэ.
- Мэс засал хийхэд үйлчлүүлэгчид мэдээ алдуулалт болон унтуулга хийхээс өмнө буюу мэс заслын өрөөнд орохоос өмнө дараах танин тодруулгыг хийнэ.
 1. Үйлчлүүлэгчийн эцэг/эх/-ийн нэр, нэр
 2. Регистрийн дугаар
 3. Төрсөн он, сар, өдөр

Үйлчлүүлэгчийг яаж танин тодруулах бэ?



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулахдаа овог нэрийг чанга тод дуугаар дуудаж, үйлчлүүлэгчтэй хамт дахин овог, нэр, төрсөн он сар, өдрийг баталгаажуулна.

Дараах тохиолдлуудад үйлчлүүлэгчийг зөв танин тодруулгыг заавал хийнэ.

Үүнд:

1. Эмч үзлэг хийхийн өмнө
2. Шинжилгээнд сорьц авахын өмнө
3. Эм, тариа тараах болон хийхийн өмнө
4. Дүрс оношилгоо, багажийн шинжилгээ хийхийн өмнө болон хариу хүргэх үед
5. Сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэхийн өмнө
6. Эмчилгээ, оношилгоо, ажилбарын өмнө
7. Мэс засал, ажилбарын өмнө
8. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэхийн өмнө
9. Яаралтай тусламж, эрчимт эмчилгээ гэх мэт оношилгоо, эмчилгээний бусад үйлдэл хийхийн өмнө
10. Хоол сойх, эмчилгээний хоол түгээхийн өмнө



Ерөнхий зарчим



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



- Бугуйн зүүлт дээрх мэдээлэл буруу, арилсан, гээгдсэн бол зөв мэдээлэлтэй бугуйн зүүлтээр нэн даруй сольж үйлчлүүлэгчийн мэдээллийг дахин тулгана
- Үйлчлүүлэгчийн ялган таних бугуйн зүүлтийг эмнэлгээс гартал зүүлгэнэ
- Хэрэв үйлчлүүлэгч бугуйн зүүлт зүүх боломжгүй (тухайлбал олон гуурс болон тоног төхөөрөмжтэй холбосон, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт) тохиолдолд эмнэлгийн хувцсанд бэхлэх эсвэл биеийн боломжит бусад хэсэгт зүүж болно.
- Үйлчлүүлэгч бугуйн зүүлт зүүхээс татгалзвал гарч болох эрсдэлийг ойлгуулж тайлбарлана.
- Үйлчлүүлэгч нас барсан тохиолдолд бугуйн зүүлт дээрх мэдээллийг нягтлан, бугуйн зүүлтийг тайлалгүй шарил хадгалах өрөө рүү зөөвөрлөнө

Бугуйвчинд тавигдах шаардлага



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



1. Үйлчлүүлэгч бүрт тохирох хэмжээтэй байх
2. Бат бөх, зөөлөн, уян хатан, усны хамгаалалттай
3. Харшил төрүүлэхгүй материалтай
4. Гар угаалга болон ариутгалын бодист тэсвэртэй
5. Эмнэлгийн нэг удаагийн хэрэглээний байх

Харилцахад **бэрхшээлтэй** үйлчлүүлэгчийг зөв танин



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Хэнийг хэлэх вэ?

1. Түр зуурын харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгч
(Ухаангүй, ихээр эм хэрэглэсэн, амьсгалын аппараттай байгаа, эрчимт эмчилгээний тасагт байгаа, сэрээх өрөөнд байгаа үйлчлүүлэгч)
2. Хэл нэвтрэлцэхгүй, орчуулагч байхгүй үйлчлүүлэгч
3. Нярай хүүхэд
4. Танин мэдэхүйн алдагдалтай (тэнэгрэл, зан төрхийн өөрчлөлтийн эмгэгүүд)
5. Хэлгүй, дүлий үйлчлүүлэгчийг харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчид

Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг таних



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Анхаарах:

Үйлчлүүлэгчийг 2 аргаар танина.

1. Үйлчлүүлэгчийн ар гэрийн гишүүд, асран хамгаалагчаас шаардлагатай мэдээллийг авч баталгаажуулна.
2. Хэрэв хувь хүний мэдээллийг тодруулах боломжгүй бол “**Овоггүй, Нэргүй**” гэж нэрлэн цахим сүлжээнд бүртгэнэ.
3. Үйлчлүүлэгчийн мэдээлэл тодорхой болсон даруйд мэдээллийг засаж бүртгэн бугуйн зүүлтийг хэрэглэнэ.
4. Шаардлагатай тохиолдолд дохионы хэлний орчуулагчаар дамжуулан танин тодруулга хийнэ.

Бугуйн зүүлтээр үйлчлүүлэгчийг танин тодруулах үед гарч болох алдаанаас сэргийлэх



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



7. Дараах тохиолдолд үйлчлүүлэгчийн мэдээллийг нягтлана. Үүнд:
 1. Бугуйн зүүлт харагдахгүй байх
 2. Бугуйн зүүлт солигдсон байх
 3. Нэгээс олон бугуйн зүүлттэй байхад зүүлт дээрх мэдээллүүд зөрүүтэй байх
 4. Бугуйн зүүлт дээрх мэдээлэл дутуу байх
 5. Бугуйн зүүлт дээрх мэдээлэл буруу байх
 6. Бугуйн зүүлт дээрх мэдээлэл гаргацгүй байх
 7. Бугуйн зүүлт дээрх мэдээлэл арилсан байх
 8. Эцэг/эх/-ийн нэр болон өөрийн нэр ижил байх
 9. Төрсөн он, сар, өдөр ижил үйлчлүүлэгч
 10. Бичиглэл өөр ч ижил дуудагддаг нэртэй үйлчлүүлэгч

- АНУ-д насанд хүрэгчдийн **5** орчим хувь нь жил бүр амбулаториар үйлчлүүлэх үедээ оношилгооны алдаанд өртдөг байна. Цогцост хийсэн задлан шинжилгээний судалгаагаар АНУ-д нас барагсдын **10** орчим хувь нь оношлогооны алдаанд өртдөг болохыг тодорхойлсон байна.
- Дэлхий даяар жил бүр **3.6** тэрбум рентген шинжилгээ хийдэг бөгөөд тэдний **10** орчим хувь нь хүүхдүүдэд хийгддэг. Мөн жил бүр **37** сая гаруй цөмийн эмчилгээ, **7,5** сая туяа эмчилгээ хийгддэг. Шаардлагагүй эсвэл мэргэжлийн бус эмчилгээний цацраг идэвхит бодисын хэрэглээ нь өвчтөн болон эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй.

- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх таагүй тохиолдлыг бууруулахад хөрөнгө оруулалт хийх нь үйлчлүүлэгчид тохиолдох сөрөг үр дагаварыг бууруулахаас гадна санхүүгийн ихээхэн хэмнэлт гаргадаг.
- Эмнэлгээс шалтгаалах халдварт **100** үйлчлүүлэгч тутмын **14** нь өртдөг болохыг хүлээн зөвшөөрсөн.
- **7** сая хүн мэс заслын хүндрэлээс тахир дутуу болж үүнээс **1** сая гаруй хүн нас бардаг байна.



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization
Representative Office
for Mongolia

Анхаарал хандуулсан та бүхэнд
баярлалаа